БАТЛАВ.

ЦЭЭЛ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА

Д.АРИУНАА

МАХНЫ ЧИГЛЭЛИЙН СЭЛЭНГЭ,КАЗАКИЙН ЦАГААН ТОЛГОЙТ ҮҮЛДРИЙН ШҮДЛЭН БУХ ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Дугаар:** ТӨАЦСЗДТГ/2023017
2. **Нэр:** МАЛЫН ҮҮЛДЭР УГСААГ САЙЖРУУЛАХ
3. **Тоо:** шүдлэн бух-9
4. **Байршил:** Төв аймгийн Цээл сум
5. **Төсөвт өртөг**: 28.0 сая төгрөг

№	Бараа техникийн тодорхойлолт, стандартын шаардлага	Нийлүүлэгчийн тодорхойлолт
Үндэслэл: Сумын засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний заалт, Цээл сумын ТЕЗахирагчийн 2023 оны ХАА-ны төлөвлөгөө, Засгийн газрын 2018 оны 400 дүгээр тогтоолын Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /2020-2023 оны/ арга хэмжээний төлөвлөгөө төслийн үндэслэл болно		
Зорилго: Газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, бүс нутгийн онцлогт тохирсон эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахад энэ төслийн зорилго оршино.		
1.1 Нийлүүлэх өсвөр бухны ерөнхий үзүүлэлт		
1.1.1	**Эрүүл мэнд:** Бруцеллёз, сүрьеэ, иж балнад, лейкоз, хөх хэлтэх, үхрийн тархи сархиатах, боом, дуут хавдар, мялзан, вибриоз, колибактериоз, трихомлиоз, шүлхий өвчний голомтгүй бүс нутгаас гаралтай, мал болох нь баталгаажуулсан байх:	
1.1.2	**Үүлдрийн онцлог шинж:** Бэлчээр ашиглах чадвар сайтай. Түргэн өсөлттэй, чийрэг бие цогцостой, тэсвэр хатуужилтай, махны өндөр ашиг шимтэй, Өөр үүлдрийн үхэртэй эрлийзжүүлэхэд толгой, гэдэс, хээлүүрийн цагааныг үр төлдөө баттай дамжуулдаг гэх мэт Сэлэнгэ, Казакийн цагаан толгойт үүлдрийн хэв шинж, стандартыг хадгалсан байх	
1.1.3	**Биеийн ерөнхий үзүүлэлт:** :Доорхи үзүүлэлтээс дээш байх: Шилбэний тойрог 17 см Биеийн ташуу урт 125 см Сэрвээний өндөр 120 см Цээжний бүслүүр 150 см Хондлойн өндөр 122 см	
1.1.4	**Нас:** Сэлэнгэ, Казакийн цагаан толгойт үүлдрийн 2 настай шүдлэн бух байх:	
1.1.5	**Зан, ааш:** Элдэв гаж араншингүй, номхон дөлгөөн байх:	
1.1.6	**Зүс:** Үндсэн зүс улаан бөгөөд толгой, сэрвээ, хондлой, хээл,	

	омруу, сүүлний үзүүр, хөлний шилбэ нь цагаан байх:	
	1.2 Нийлүүлэх өсвөр бухны үржлийн үзүүлэлтүүд:	
1.2.1	Бух бүр хувийн дугаартай, эцэг, эхийн гарваль, ашиг шим тодорхой, эцэг нь үр төлийн чанараар шалгагдсан байх бөгөөд эдгээр нь баталгаажсан гэрчилгээтэй байх;	
1.2.2	Амьдын жин 400-450 кг-аас дээш байх;	
1.2.3	Тарга хүчтэй, бие галбирын согоггүй, хэвийн хөгжилтэй байх;	
1.2.4	Бэлэг эрхтний хөгжил хэвийн, бэлгийн идэвх сайтай байх;	
	1.3. Нийлүүлэх өсвөр бухны үнэ:	
1.3.1	Нийлүүлэх өсвөр бухны нэгж үнэ(мян.төг)	

	3. Хяналт, хүлээн авах зардал	
3.1	Сэлэнгэ аймгийн Хушаат, Орхонтуул, Булган аймгийн Сэлэнгэ сумдад худалдан авч байгаа үхрийг газар дээр нь очиж үзэх, Төв аймгийн Цээл суманд үхрийг хүлээж авахаар ажлын хэсэг газар дээр нь ажиллах томилолт, шатахууны зардал 500 000 төгрөг шаардлагатай.	

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:
ХААТ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН МАЛЫН ИХ ЭМЧ У.БАТМӨНХ